

ГАРЧИГ

БҮЛЭГ I. ОРШИЛ	3
БҮЛЭГ II. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
II.1. Төслийн нэр	4
II.2. Төсөл хэрэгжүүлэгч	4
II.3. Төслийн байршил	4
II.4. Хүчин чадал.....	6
II.5. Химийн бодисын хэрэглээ	6
II.6. Энгийн тэсрэх бодисын үйлдвэр	6
II.7. Тэсрэх материалын агуулах	7
II.8. Захиргаа аж ахуйн барилга	8
II.9. Үйлдвэрийн лаборатори.....	9
II.10. Туршилтын талбай	10
БҮЛЭГ III. ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	11
БҮЛЭГ IV. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	12
БҮЛЭГ V. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ	13
V.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	13
V.2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт	19
V.3. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	21
V. 4. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	21
V.5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	27
V.6. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	31
Орон нутагтай хамтарч ажилласан талаар:.....	31
V.7. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөний биелэлт	33
V.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт.....	36
ДҮГНЭЛТ	38
АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ	39

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл	4
Хүснэгт 2. Талбайн цэгүүдийн солбилцол.....	4
Хүснэгт 3. Нийт хүчин чадал.....	6
Хүснэгт 4. Хэрэгцээнд шаардагдах химийн бодисын хэмжээ, эх үүсвэр	6
Хүснэгт 5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	13
Хүснэгт 6. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт.....	19

Хүснэгт 7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	21
Хүснэгт 8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	27
Хүснэгт 9. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт.....	31
Хүснэгт 10. Олон нийтэд тайлагнах, танилцуулах төлөвлөгөөний биелэлт.....	35
Хүснэгт 11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөөний биелэлт	36
Хүснэгт 12. 2022 оны БОМТ-нд зарцуулсан нийт зардал.....	37

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. “Тэсрэх бодисын үйлдвэр, агуулах”-ын байршлын зураг.....	5
Зураг 2. “Тэсрэх бодисын үйлдвэр, агуулах”-ын харагдах байдал.....	5
Зураг 3. Энгийн тэсрэх бодисын үйлдвэрлэлт.....	7
Зураг 4. Тэсрэх материал, түүхий эдийн агуулах.....	8
Зураг 5. Аж ахуйн хэсгүүд	8
Зураг 6. Үйлдвэрийн хяналтын лаборатори.....	9
Зураг 7. Тусгайлан тоногдсон туршилтын талбай.....	10
Зураг 8. Үйлдвэр, агуулахад анхааруулах самбар, тэмдэг тэмдэглэгээ байршуулсан байдал.....	16
Зураг 9. Тэсэлгээний бодисыг битүү шуурган дамжуурганд хольдог.....	16
Зураг 10. Хогийг ангилан ялгах, бетонон суурь бүхий хогийн цэг	17
Зураг 11.....	17
Зураг 12. Үйлдвэр, агуулахын технологийн зам	18
Зураг 13. Тэсэлгээний бодисын хадгалалтын байдал	18
Зураг 14. Үйлдвэр, агуулахын хашааг тохижуулсан байдал	20
Зураг 15. Тэсэлгээний бодисын хадгалалтын байдал	24
Зураг 16. Гал түймрээс урьдчилан сэргийлэх багаж хэрэгслийг байршуулсан байдал..	24
Зураг 17. Үйлдвэр, агуулахад галын хорыг байршуулсан байдал.....	25
Зураг 18. Гал түймрээс урьдчилан сэргийлэх багаж хэрэгсэл, анхны тусламжийн багаж хэрэгсэл, эмийн сан зэргийг байршуулсан байдал	25
Зураг 19. Тоноглол, газардуулга, эсэргүүцэл хэмжсэн протокол	26
Зураг 20. Хог хаягдлыг ангилах ялгах хогийн сав	29
Зураг 21. Хог хаягдлын мэдээллийн санд бүртгэгдсэн.....	29
Зураг 22. “Цэцүүх трейд” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу сав баглаа боодлын хог хаягдлыг устгуулсан баримт	30
Зураг 23. Подволь засч тохижуулсан байдал	33
Зураг 24. Подволь засч тохижуулсан байдал	33
Зураг 25. Урлагийн наадмыг ивээн тэтгэсэн байдал	34
Зураг 26. Урлагийн наадмыг ивээн тэтгэсэн байдал	34

БҮЛЭГ I. ОРШИЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

“Тэсрэх бодисын үйлдвэр, агуулах”-ын төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний үндсэн зорилго нь төслийг хэрэгжүүлэх явцад үүсэх бүхий л сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзэн, холбогдох зардлыг бодитоор төлөвлөх, улмаар энэхүү төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч дагаж мөрдсөнөөр байгаль орчин, нийгмийн хамгааллын үүргээ хангах нөхцөлийг бүрдүүлэх юм.

БОМТ-ний биелэлтийн тайлан боловсруулах аргачлал:

“Тэсрэх бодисын үйлдвэр, агуулах”-ын 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг боловсруулахдаа байгаль орчин, аялал жуучлалын сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29 –ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан аргачлалын дагуу энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн 11 дүгээр сарын 01-ны дотор тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийн хамт холбогдох байууллагад хүргүүлж байх зайлшгүй шаардлагатай болно.

“Тэсрэх бодисын үйлдвэр, агуулах”-ын төслийн БОМТ-ний биелэлтийн тайланд 2022 онд нийт **41,209,000.00** төгрөг зарцууллаа.

БҮЛЭГ II. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

№	Үзүүлэлтүүд		
1	Аж ахуйн нэгжийн нэр		“Мастер майнинг сервис” ХХК
2	Регистрийн дугаар		5889782
3	Төслийн нэр		“Тэсрэх бодисын үйлдвэр, агуулах”-ын төсөл
4	Төслийн	Нийслэл/Хот/ Аймаг	Улаанбаатар хот
5	байршил	Сум/Дүүрэг	Багахангай дүүрэг, 2-р хороо
6	Газар ашиглалтын зориулалт		
7	Аж ахуйн	Аймаг/Хот	Улаанбаатар хот
8	нэгжийн	Сум/Дүүрэг	Хан-уул дүүрэг
9	хаяг	Баг/Хороо	15-р хороо, Эм Эн Эс Бюлдинг ХХК-ийн байр
10	Захирлын	Нэр	Захирал Б.Баярбат
11	хаяг	Гар утас	976-88889094

II.1. Төслийн нэр

“Тэсрэх бодисын үйлдвэр, агуулах”-ын төсөл

II.2. Төсөл хэрэгжүүлэгч


“МАСТЕР МАЙНИНГ СЕРВИС” ХХК

II.3. Төслийн байршил

Төслийн талбай нь Улаанбаатар хотоос зүүн урагш 90 км, Багахангай дүүргээс зүүн зүгт 3км зайд байрлалтай байна. Тус талбайн булангийн цэгийн солбицолыг хүснэгтээр үзүүлээ.

Хүснэгт 2. Талбайн цэгүүдийн солбилцол

№	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	107	31	33.62	47	22	21.32
2	107	31	40.02	47	22	23.13
3	107	31	43.73	47	22	17.21
4	107	31	37.19	47	22	15.32



Зураг 1. “Тэсрэх бодисын үйлдвэр, агуулах”-ын байршлын зураг



Зураг 2. “Тэсрэх бодисын үйлдвэр, агуулах”-ын харагдах байдал

II.4. Хүчин чадал

Уурхайн зориулалттай тэсрэх бодисын үйлдвэрийн хүчин чадлыг төсөл захиалагч байгууллагын техникийн даалгавар, одоогийн бэлтгэгдэж байгаа болон хүлээгдэж байгаа зах зээлийн багтаамж, төсөл хэрэгжүүлэгчийн ханган нийлүүлэлт хийж буй гэрээт байгууллагуудын хэрэгцээнд тулгуурлан тодорхойлсон болно. Мөн тус үйлдвэр агуулахын цогцолборын талбайд тэсрэх бодис тэсэлгээний хэрэгслийн агуулахуудыг барьж байгуулсан ба нэмэлтээр түүхий эдийн 2 агуулахыг тус бүр 300 тн хүчин чадалтайгаар барихаар төлөвлөж байна.

Хүснэгт 3. Нийт хүчин чадал

№	Үйлдвэрүүд	Хэмжих нэгж	Хүчин чадал
1	Энгийн найрлагат тэсрэх бодис /АНФО/ үйлдвэр	тн/жил	5000
2	Түүхий эдийн агуулах	тн	60
3	Тэсрэх бодисын агуулахын багтаамж	тн	13
4	Тэсрэх хэрэгслийн агуулахын багтаамж	тн	13
5	Тэсэлгээний өдөөгчийн агуулахын багтаамж		17

II.5. Химийн бодисын хэрэглээ

Тэсрэх бодисын үйлдвэрийн технологит доорх нэр төрлийн химийн бодисуудыг ашигладаг. Аммоны нитрат (аммиакийн шүү), дизелийн түлш, хөнгөн цагааны нунтаг зэрэг химийн бодисыг үйлдвэрийн технологийн үйлдвэрлэл буюу бүтээгдэхүүний найрлагын түүхий эд байдлаар ашигладаг.

Хүснэгт 4. Хэрэгцээнд шаардагдах химийн бодисын хэмжээ, эх үүсвэр

№	Монгол нэр	Олон улсын нэр	Томьёо	Нийлүүлэлт	Хэмжээ
1	Аммиакийн шүү	Ammonium nitrate	NH ₄ NO ₃	Импортоор	4700 тн
2	Дизелийн түлш	Diesel fuel	-	Дотоодын зах зээл	308 тн
3	Хөнгөн цагааны нунтаг	Aluminium	Al	Импортоор	50 тн
4	Ашигласан тос	Oil	-	Дотоодын зах зээл	50 тн

II.6. Энгийн тэсрэх бодисын үйлдвэр

Энгийн найрлагатай тэсрэх бодисын үйлдвэр нь жилд 5000тн тэсрэх бодис үйлдвэрлэх хүчин чадалтай байх бөгөөд үйлдвэрийн Tread T-1 маркийн тоног төхөөрөмжийг 10x8 метр хэмжээтэй сэндвичэн барилгад суурилуулахаар төлөвлөсөн ба үйлдвэрийн байр дотор 10 м³ багтаамжтай дизель түлшний танкийг хамт байрлуулахаар төлөвлөж байна.

Тус үйлдвэрийн байршлыг сонгохдоо үндсэн түүхий эд аммиакийн шүүний агуулахтай харьцангуй ойр байрлуулахаар төлөвлөсөн ба мөн бэлэн бүтээгдэхүүн хадгалах агуулах

хүртэлх зайг агуулахын аюулгүйн зайг үндэслэн тооцсон. Үйлдвэр нь энгийн тэсрэх бодисыг тухайн газрын чулуулгийн хатуулаг, орчны шинж чанарт тохируулан Энгийн буюу "ROCK MASTER", Хүчитгэсэн буюу "ROCK MASTER-X", гэсэн 2 төрлөөр үйлдвэрлэж, полиэтилен дотортой, полипропилен гадартай давхар уутанд 25 кг-аар шуудайлан савлаж байна.



Зураг 3. Энгийн тэсрэх бодисын үйлдвэрлэлт

II.7. Тэсрэх материалын агуулах

Үйлдвэрийн агуулахууд нь түүхий эд, туслах материалын, импортын эмульсийн тэсрэх бодисын, тэсрэх хэрэгслийн, бүтээгдэхүүний (ANFO) гэж ангилагдах бөгөөд агуулахын хамгийн их багтаамж нь (аммиакийн шүү орохгүйгээр)-60 тн, тэсрэх бодис-50 тн, тэсэлгээний хэрэгсэл-26 тн хадгалах хүчин чадалтай.

Багахангайн тэсрэх бодис, түүхий эд материалын агуулахуудыг ТААНД-ийн шаардлагын дагуу тоногдсон бөгөөд эдэлбэрийн зүүн хэсгийг шороон далангаар тусгаарлан, аянга зайлуулагчаар аянгаас хамгаалсан хоёр хоёроор нь зэрэгцүүлэн барьсан агуулахуудад хадгалдаг.



Зураг 4. Тэсрэх материал, түүхий эдийн агуулах

II.8. Захиргаа аж ахуйн барилга

Тус үйлдвэр агуулахын талбайд оффисын болон ажиллагсадын хувцас солих, түр амрах, ажлын хурал хийх, лабораторийн өрөө гэх хуваалт хийгдсэн өрөөнүүдийг ашиглахаар төлөвлөсөн. Үйлдвэр агуулахын цогцолбор нь харьцангуй гар ажиллагаа багатай тул үйлдвэрт ажиллах хүний нөөц үүнийг дагаад цөөн байна. Тиймдээ ч ажилчдын хувцас солих өрөө болон захиргааны ажилчдын оффисыг нэг барилгад багтаан барьж байгуулахаар төлөвлөөд байна.

Мөн үйлдвэрийн байр, бэлэн бүтээгдэхүүний болон түүхий эдийн агуулах, оффисын барилга зэрэг шаардлагатай газруудад 12 ширхэг хяналтын камер байрлуулан интернетийн сүлжээтэй байрлалаас 24 цагийн турш хянаж байна.



Зураг 5. Аж ахуйн хэсгүүд

II.9. Үйлдвэрийн лаборатори

Лаборатори нь энгийн найрлагатай тэсрэх бодисын суурин үйлдвэр агуулахын цогцолборт ажилчдын оффисын байрны хажууд зэрэгцээгээр байгуулах ба 40 тн-н контейнерийг лабораторийн зориулалтаар тохижуулж тоноглон ашиглана.

Лабораторийн байр нь агаар сэлгэгчээр тоноглогдсон байх ба байгалийн гэрэлтүүлэг сайтай байхаар цонх гаргасан байна. Лаборатори нь үйлдвэрлэлийн процесс, түүхий эдүүдийн шинж чанар болон үйлдвэрийн бэлэн бүтээгдэхүүн тэсрэх бодисын шинж чанарын үзүүлэлтийг хянах зориулалттай.

Үйлдвэрийн технологийн оператор нь анхдагч түүхий эд болон эцсийн бүтээгдэхүүн тэсрэх бодисын шинж чанарын үзүүлэлтэнд хяналт тавьж туршилт шинжилгээний ажлыг гүйцэтгэж байх ба лаборатори нь үйлдвэрийн үйл ажиллагаатай уялдаж ажиллана. Лабораторит дараах шинжилгээнүүд хийгдэнэ. Үүнд:

- Тэсрэх бодисын шингээх чадварыг тодорхойлох,
- Мөхлөгийн бүтцийг тодорхойлох,
- Нягтыг тодорхойлох,
- Бутрамтгай чанарыг тодорхойлох,
- Чийглэг тодорхойлох.

Лабораторийн байранд нэг химич инженер үйлдвэрийн ажиллах цагийн хуваарийн дагуу ажил гүйцэтгэх ба үйлдвэрээс гарах тэсрэх бодист хийх шинжилгээ болон түүнд орж буй түүхий эдийн шинж чанарт байнгын хяналт шалгалт хийж ажиллана.

Лаборатори нь тэсрэх бодисын шинж чанар болон түүхий эдүүдийн хяналтын шинжилгээг тогтмол явуулах ба угаалтуур болон дараах тоног төхөөрөмжийн иж бүрдэл бүхий лабораторийн ширээ суурилагдана.



Зураг 6. Үйлдвэрийн хяналтын лаборатори

II.10. Туршилтын талбай

Үйлдвэрээс гарсан бүтээгдэхүүн /тэсрэх бодис/-ийн туршилтын ажлыг явуулахдаа зориулалт бүхий тусгайлан зассан далан болон хашаагаар хүрээлэгдсэн талбай бүхий цэгийг байгуулна. Энд тэсрэх бодисын чанар, тэсрэлтийн хүч зэргийг тодорхойлох туршилтын бага хэмжээний тэсэлгээ хийгдэх тул энэ нь үйлдвэрийн бүс дэх онцгой объектуудын нэг юм.

Туршилтын талбайд 3м радиустай, өндөр нь 3м хэмжээтэй ёмкостиг хагас далдлан булж дотоод орон зайд нь газрын гадаргатай ижил түвшинд хүртэл нь шороогоор дүүргэх ба ёмкостиг агаарын цохилтын долгион, дуу чимээ гадагшилж байхаар хэд хэдэн дээш харсан яндан гарган нүхлэнэ. Туршилтын талбай нь шалган нэвтрүүлэх байрнаас 60 метр зайд, Аммиакийн шүүний агуулахаас-150 метр, ТБ-ын агуулахаас 115 метрийн зайд байрлана. Тус объектийг дараах байдалтайгаар байгуулахаар төлөвлөж байна.



Зураг 7. Тусгайлан тоногдсон туршилтын талбай

БҮЛЭГ III. ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь тухайн төслөөс байгаль орчинд учруулах гол сөрөг нөлөөлөл болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг тодорхойлж түүнд шаардагдах хөрөнгө зардлыг тусгадаг.

“МАСТЕР МАЙНИНГ СЕРВИС” ХХК нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 11-р сарын 01-ны дотор төсөл хэрэгжүүлж байгаа аймаг, нийслэлийн байгаль орчны газарт хүргүүлж байх шаардлагатай.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайланг БОАЖСайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулж, холбогдох материалуудыг хавсаргалаа.

Тухайн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн товч танилцуулга

2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажлын гол зорилго нь “Тэсрэх бодисын үйлдвэр агуулах”-ын төслийн үйл ажиллагааны бүхий л үе шатыг хамрах ба төслийн үйл ажиллагаанас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг болзошгүй гол нөлөөлөл болон цаашид учруулж болзошгүй эерэг болон сөрөг нөлөөллийг бууруулах, багасгах, төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино.

“МАСТЕР МАЙНИНГ СЕРВИС” ХХК нь нь 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу сөрөг нөлөөллийг бууруулах ажлуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажилласан.

БҮЛЭГ IV. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл:

- Тэсрэх бодис тээвэрлэлтийн үед тоосжилт үүсэх,
- Тээврийн хэрэгслийн яндангаас ялгарах хорт бодис, утаа тортог, хий,
- Хог хаягдлыг ил задгай хаяснаас үүсэх үнэр,
- Дуу чимээний нөлөөлөл үүсэх,

Газрын гадарга, хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл:

- Үйлдвэр болон агуулахын суурь хэсгийн хөрсөн бүрхэвч нөлөөлөлд өртөнө,
- Түүхий эдийн сав баглаа боодол хаягдаж, хөрс бохирдуулах,
- Тээвэрлэлт болон үйлчилгээний тээврийн хэрэгслүүд олон салаа зам гаргаснаар хөрс эвдрэх,
- ШТМ асгарч хөрс бохирдох.

Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл:

- ШТМ асгарч газрын доорх ус бохирдох,
- Ахуйн шингэн хог хог хаягдлыг ил задгай асгаснаас газрын доорх ус бохирдох.

Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл:

- Үйлдвэрийн суурь хэсгийн хөрсөн бүрхэвч нөлөөлөлд өртөнө,
- Агаарын бохирдлын эх үүсвэр болох учир шимт хөрсний чанарт дам нөлөөлөлд үзүүлнэ,
- Ахуйн хаягдлаар үйлдвэрийн орчин бохирдох.

Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл:

- Үйлдвэр, агуулахын суурийн хэсгийн ургамлан бүрхэвч устаж үгүй болох, үйлдвэрээс гарах тоос нь орчны ургамлан бүрхэвчийн бүтцэд нөлөөлж улмаар доройтол үүсгэх,
- Агаарын бохирдлын эх үүсвэр болж байгаа учир ургамлан бүрхэвчид дам нөлөөлөл үзүүлнэ,
- Тээвэрлэлтийн нөлөөгөөр олон салаа зам гарснаар ургамал талхлагдах.

Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөлөл:

- Тэсэлгээний бодис хөрсөнд асгарсан тохиолдолд амьтны амьтны аймагт сөрөг нөлөөлөл,
- Үйлдвэрийн дуу чимээ, тоосжилт зэрэг нь амьтдын шилжилт хөдөлгөөн, амьдрах орчинд сөрөг нөлөөлөл үзүүлнэ. Мөн хөрсний бичил биетэн устаж үгүй болно.

БҮЛЭГ V. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖЕМНЕТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

V.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зардал, 2022 он /төгрөг/
Агаарын орчин			
1	Ажлын байр, агуулах, зэрэг барилгуудын агааржуулалтын системийн хэвийн ажиллагааг хангах	Ажлын байр, агуулах, зэрэг барилгуудын агааржуулалтын системийн хэвийн ажиллагааг хангаж ажилласан.	-
2	Төсөл орчмоос гарч байгаа дуу чимээг стандартын түвшинд байлгах, давсан тохиолдолд эх үүсвэрийг тодорхойлж, багасгах арга хэмжээ авах.	Үйлдвэр, агуулахаас гарч буй дуу чимээг стандартын түвшинд байлгаж ажилладаг, дуу чимээний нөлөө гарах нь бага.	-
3	Тэсэлгээний бодисын халаалтын хэрэгсэл, цахилгааны эх үүсвэрээс хол, нарны гэрэл шууд тусахааргүй нөхцөлд хадгалах.	Тэсэлгээний бодисын халаалтын хэрэгсэл, цахилгааны эх үүсвэрээс хол, нарны гэрэл шууд тусахааргүй нөхцөлд агуулахад хадгалдаг.	-
4	Тэсэлгээний бодисын агуулах барилга байгууламжийг MNS6458:2014 стандартад нийцүүлэх	Тэсэлгээний бодисын агуулах барилга байгууламжийг MNS6458:2014 стандартад нийцүүлж барьсан.	Дотоод төлөвлөлтөөр
5	Тэсэлгээний бодис холих, уусгах үйлдлийг битүү саванд буюу хий тархахаас хамгаалсан нөхцөлд хийх	Битуу шурган дамжуургад хольдог	-
6	Хуурай болон салхины хурд ихтэй үед автозам, талбайг услах	Авто зам талбайг услаж байсан.	-
7	Автотээврийн болон хүнд машин механизмын хөдөлгүүрийн сул ажиллагааг хязгаарлах	Автотээврийн болон хүнд машин механизмын хөдөлгүүрийн сул ажиллагааг хязгаарласан, сул асаалттай орхидоггүй.	-

Газрын гадарга, Хөрсөн бүрхэвч			
1	Тэсэлгээний бодис тээвэрлэх тээврийн хэрэгслийг тогтоосон маршрутаар явуулах	Тэсэлгээний бодис тээвэрлэх тээврийн хэрэгслийг тогтмол тогтоосон маршрутаар явуулдаг.	-
2	Тэсэлгээний бодистой холбоотой үйл ажиллагаа явуулж байгаа агуулах, үйлдвэрийн барилга байгууламж, шал зэрэгт байнгын үзлэг шалгалт хийж, эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд дор нь засварлах.	Тэсэлгээний бодистой холбоотой үйл ажиллагаа явуулж байгаа агуулах, үйлдвэрийн барилга байгууламжинд байнгын үзлэг шалгалт хийж, эвдрэл гэмтлийг засварлаж байсан.	-
3	Ахуйн хог хаягдлыг хөрс бохирдуулахаас сэргийлсэн зориулалтын сав, цэгт төвлөрүүлж, хөрсөнд алдагдахаас сэргийлэн сав, цэгийн тохиожолт, засвар үйлчилгээг хийх.	Хогийг ангилж хаях зориулалттай, хөрсөнд нэвчихээс хамгаалсан бетонон суурь бүхий хогийн цэгийг бий болгосон.	3,000,000
4	Бүх төрлийн шингэн хаягдал хаях цэгийг хөрсөнд үл нэвчих байгууламжид хуримтлуулах, хальж асгарахаас сэргийлэх.	Манай үйлдвэрт ус болон бусад шингэн түүхий эд бодис хэрэглэдэггүй учраас шингэн хог гардаггүй.	-
5	Үйлдвэр орчмын ба дотоодын тээврийн замыг тэгшлэн засах.	Үйлдвэр болон агуулах хооронд технологийн замтай, тухай бүрт замыг засварладаг.	-
6	Шинээр зам үүсэхээс урьдчилан сэргийлж, тэмдэгжүүлэх, анхааруулах самбарын өнгө үзэмжийг сайжруулах.	Үйлдвэрийн хашаанд зөвхөн технологийн замаар зорчдог учраас шинээр зам үүсгэх боломжгүй, анхааруулах самбарын өнгө үзэмжийг тухай бүрт сайжруулж ажилласан.	300,000
7	Тээврийн хэрэгслийг шатах тослох материалаар цэнэглэх засвар үйлчилгээг зориулалтын талбайд хийх	Тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ хийх талбай байхгүй	-
8	Тэсэлгээний бодис, шатах тослох материалын хадгалалт, ашиглалтанд байнгын хяналт тавих	Тэсэлгээний бодис, шатах тослох материалын хадгалалт, ашиглалтанд байнгын хяналт тавьж ажилладаг.	-

Усан орчин			
1	Тэсэлгээний бодис хадгалах болон ашиглаж буй газар үерийн хамгаалалт, даланд үзлэг шалгалт хийж, засварлаж байх	-	-
2	Бохир усны хяналтын шинжилгээг хийлгэх	Ус ашигладаггүй.	-
3	Ахуйн хэрэглээнээс гарсан бохир усыг тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгжид тушаах	Унд ахуйн уснаас бусад үед ус ашигладаггүй.	-
Нийт дүн			3,300,000



Зураг 8. Үйлдвэр, агуулахад анхааруулах самбар, тэмдэг тэмдэглэгээ байршуулсан байдал



Зураг 9. Тэсэлгээний бодисыг битүү шуурган дамжуурганд хольдог



Зураг 10. Хогийг ангилан ялгах, бетонон суурь бүхий хогийн цэг



Зураг 11.



Зураг 12. Үйлдвэр, агуулахын технологийн зам



Зураг 13. Тэсэлгээний бодисын хадгалалтын байдал

V.2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 6. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зардал, 2022 он /төгрөг/
1	Хөрсөн бүрхэвчийн элэгдэл, эвдрэлийг багасгах, агаар дахь тоосонцорын хэмжээг бууруулах зорилгоор мод тарих /Эсвэл дүүрэг орон нутагт мод тарих/ байгуулах Үйлдвэрийн хашааны өнгө үзэмжийг сайжруулан тохижуулах.	Үйлдвэр, агуулахын хашааг сайжруулж тохижуулсан. 2023 онд мод тарихаар төлөвлөсөн.	8,000,000
	Нийт		8,000,000



Зураг 14. Үйлдвэр, агуулахын хашааг тохижуулсан байдал

V.3. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Үйлдвэр, агуулахын талбай болон түүний нөлөөллийн бүсэд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл ба археологийн олдвор илрээгүй учир хийгдэхгүй болно.

V. 4. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Нийт зардал, 2022 он /төгрөг/
1	Химийн бодис алдагдсан тохиолдолд тухайн бодисыг цаашид тархахаас нь сэргийлж, шуурхай шингээн авах, орон нутгийн төрийн байгууллагад мэдэгдэх	Тэсрэх бодисын үйлдвэр агуулахын үйлдвэрийн ослоос урьдчилан сэргийлэх төлөвлөгөөтэй ажилладаг. Харьяа дүүрийн Онцгой байдлын хэлтсээр батлуулсан. Химийн бодис асгарч, алдагдахаас сэргийлж, хяналт тавьж ажилласан.	-
2	Тэсрэх бодисын агуулах болон үйлдвэрийн барилга байгууламжийн бэлэн байдлыг хангах	Тэсрэх бодисын агуулах болон үйлдвэрийн барилга байгууламжийн аюулгүй байдалд хяналт тавьж ажилласан.	-
3	Тэсэлгээний бодистой холбоотой үйл ажиллагаа явуулах өрөө тасалгаа, агуулахад хоорондоо үл зохицох (хамтад нь хадгалж болдоггүй) бодисуудыг хамт хадгалахгүй байх.	Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тусад нь хадгалсан.	-
4	Тэсрэх бодисын хадгалалт хамгаалалтын аюулгүй ажиллагааны дүрмийг сахих, алдагдах нөхцлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах хяналт байнга тавих	Тэсрэх бодисын хадгалалт хамгаалалтын аюулгүй ажиллагааны дүрмийг сахиж ажилласан, алдагдахаас сэргийлж урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байнгын хяналт тавьж ажилласан.	-

5	Тэсэлгээний бодисын нэг агуулахад 500 тонноос, агуулахын доторхи нэг тасалгаанд 50 тонноос ихгүй бодис хадгалах ялангуяа шатамхай шингэнийг халаалтын хэрэгсэл, системээс хол, шууд нарны гэрэл тусахааргүй, үер усанд автахааргүй нөхцөлд хадгална	Тэсэлгээний бодисын нэг агуулахад 500 тонноос, агуулахын доторхи нэг тасалгаанд 50 тонноос ихгүй хадгалж, нарны гэрэл тусахааргүй, үер усанд автахааргүй нөхцөлд хадгалж байсан.	-
6	Гал түймэр эсэргүүцэх ажлын зохион байгуулалт, багаж хэрэгслийн бүрдлийн нөхөн хангалт хийх	Гал түймэр, гал түймрээс хамгаалах багаж хэрэгслээр үйлдвэр агуулахыг хангасан.	2,000,000
7	Ажлын байранд гал гаргахыг хатуу хориглосон анхааруулга тэмдэгээг шинэчилж сайжруулах	Гал түймрээс урьдчилан сэргийлэх анхааруулах самбар, тэмдэг тэмдэглэгээг үйлдвэр, агуулахад байршуулсан.	300,000
8	Гал хорны ажиллагааг тогтмол шалгаж тэмдэглэл хөтөлж байх	Галын хорыг тогтмол шалгаж, хяналт тавьж ажилласан.	-
9	Төслийн нийт талбайд байрлах аянга зайлуулагч, барилга байгууламжийн газардуулгын эсэргүүцлийг хийлгэх	Үйлдвэр, агуулахын талбайд аянга зайлуулагч, барилга байгууламжийн газардуулга эсэргүүцлийг байршуулсан.	2,000,000
10	Нэг бүрийг хөдөлмөр хамгааллын хэрэгслэлээр (ажлын хувцас, өвөл, зуны гутал, хамгаалалтай нүдний шил, бээлий, чих бөглөгч г.м) хангах	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангаж ажилладаг.	500,000
11	Ажилчдад ослын үед цаг алдалгүй анхны тусламж үзүүлэх зорилготой анхны тусламж үзүүлэх эмийн сангийн бүрдэлтийг шинэчлэх	Үйлдвэрт анхны тусламж үзүүлэх эмийн санг бүрдүүлж, шаардлагатай эмийг бэлэн байлгадаг.	100,000
12	Ажилчдыг ослын үед өөртөө болон бусдад үзүүлэх эмнэлгийн анхан шатны тусламжийн арга барилд сургах арга хэмжээ	Ажилчдыг эмнэлгийн анхан шатны тусламжийн арга барилд сургаж, зааварчилгаа өгсөн.	300,000

13	Ажиллагсдыг ажилд ороход эмнэлгийн үзлэгт оруулж, эрүүл мэндийн хувьд тэнцэх эсэхийг тодорхойлсон байх ба эрүүл мэндийн үзлэгт жилд нэг удаа хамруулахын зэрэгцээ эрүүлжүүлэх арга хэмжээ зохион байгуулах	Ажилчдыг ажилд орохын өмнө эрүүл мэндийн хуудсыг авч ажилд авдаг, мөн ажилчдыг жил бүр эрүүл мэндийн урьчилан сэргийлэх үзлэгт хамруулдаг	300,000
Нийт			5,500,000



Зураг 15. Тэсэлгээний бодисын хадгалалтын байдал



Зураг 16. Гал түймрээс урьдчилан сэргийлэх багаж хэрэгслийг байршуулсан байдал



Зураг 17. Үйлдвэр, агуулахад галын хорыг байршуулсан байдал



Зураг 18. Гал түймрээс урьдчилан сэргийлэх багаж хэрэгсэл, анхны тусламжийн багаж хэрэгсэл, эмийн сан зэргийг байршуулсан байдал

Тоноглолын газардуулгын эсэргүүцэл хэмжсэн ПРОТОКОЛ № 00000950

УБЦТС ХК _____ ХУТ _____ Протокол бичигдсэн өдөр 2019 оны 06 сарын 26 өдөр
 Байгууллагын нэр Насны 77 Протоколын хүчинтэй хугацаа 2019 оны 06 сарын 26 өдрийг хүртэл

Замчлалт өгсөн Хөдөө аж ахуйн газар Замчлалт өгсөн хэргийн үндэсний код № _____
 Хэмжээтэй хайсан хүний албан тушаал А.С.Х. Хэмжээтэй хайсан хэргийн үндэсний код № _____
 Хэмжээтэй хайсан биологийн төр А.Х.Б.М. Хэрэглэж байгаа эмгэгчдийн эхний үсэг № 15.1.1.1 Өдөр _____

№	Тонголлын нэр	Газардуулгын тонголлын нэр	Газардуулгын эсэргүүцэл /См ³	Дүгээлт
1.	А.Х.Б.М. 1	А.Х.Б.М. 1	4.59	7214200
2.	А.Х.Б.М. 2	А.Х.Б.М. 2	5.43	7214200
3.	А.Х.Б.М. 3	А.Х.Б.М. 3	2.43	7214200
4.	А.Х.Б.М. 4	А.Х.Б.М. 4	4.	7214200

Жич: Хэрэглэгчид өөрөөр шалт, тонголлогоо баримтлан зохион, нэмэгдүүлж, тухайн газардуулга дээр хэмжээтэй, протокол хийж өгсөн үзүүлэлтүүдийг үз.

Хэмжээтэй хайсан: А.С.Х. Шалтсан: А.Х.Б.М.

Зураг 19. Тоноглол, газардуулга, эсэргүүцэл хэмжсэн протокол

V.5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт


Хүснэгт 8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зардал, 2022 он /төгрөг /
1	Хог хаягдал /хатуу/	Ахуйн гаралтай хоёрдогч түүхий эдийг ангилан цуглуулах	Ахуйн гаралтай хоёрдогч түүхий эдийг ангилан цуглуулж, тээвэрлүүлсэн	-
2		Хог хаягдлыг түр хадгалах цэг, хог савнуудын өнгө үзэмж, чанарыг сайжруулах	Хог хаягдлын хогийн савыг байршуулсан, хог хаягдлыг түр хадгалах цэг бий болгосон.	-
3		Хог хаягдлын цэгийг тогтмол ариутгаж байх	-	-
4		Үйлдвэрийн ажилчдад хог хаягдлыг хэрхэн ангилан ялгах, боломжтойг нь дахин ашиглах талаар сургалт явуулах	Ажилчдад хогийг ангилан ялгах талаарх заавар, зөвлөмж өгч, сургалтанд хамруулсан.	-
5		Хог хаягдлыг ил задгай, зориулалтын зуухнаас бусад байдлаар шатаахыг хориглоно	Хог хаягдлыг ил задгай хаяагүй, тухай бүрт орчны цэвэрлэгээ хийсэн, хог хаягдлыг шатаагаагүй.	-
6		Ахуйн хатуу хог хаягдлыг орон нутгийн тусгай зөвшөөрөл бүхий ТҮК-д ачуулж зайлуулах	Ахуйн хог хаягдлыг хог хаягдлын гэрээ байгуулж тухай бүрт тээвэрлүүлсэн.	350,000
7		Нэвчилт явагдахааргүй битүүмжлэл бүхий цооног саванд бохир усыг хуримтлуулж, зайлуулах	-	-
8	Үйлдвэрийн	Тэсэлгээний бодисын хаягдал, үлдэгдлийг үйлдвэрлэлийн хаягдал материал устгахад	“Цэцүүх Трэйд” ХХК -тай гэрээ байгуулсан гэрээний дагуу тээвэрлүүлж, устгуулдаг.	759,000

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зардал, 2022 он /төгрөг /
		мэргэшсэн мэргэжлийн байгууллагаар устгуулах ба төрийн эрх бүхий хяналтын байгууллагыг оролцуулах		
9	Аюултай	Тэсрэх бодисын уут, сав баглаа боодлыг зориулалтын стандартын шаардлага хангасан цэгт төвлөрүүлэн хадгалах	Тэсрэх бодисын сав баглаа боодлыг Хог хаягдал дахин боловсруулах устгах үйлдвэр “Цэцүүх Трэйд” ХХК -тай гэрээ байгуулан ажиллаж, тээвэрлүүлж, устгуулдаг	
10		Хаягдал баттерэй /хуруу зайг/ цуглуулан Монголын хог хаягдлын холбоонд тушаах	Хаягдал баттерэйг цуглуулж, хаягдал баттэрэй авдаг газарт тушаадаг.	-
11		Автомашин хөдөлгүүрийн хаягдал тосыг цуглуулан үйлдвэрлэлдээ дахин ашиглах	Автомашинаас хаягдал шатах тослох материалын үлдэгдэл гараагүй.	-
Нийт дүн				1,109,000



Зураг 20. Хог хаягдлыг ангилах ялгах хогийн сав


**УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБА**
Хангайн ардун Д.Мөнх-Очирын суурин 7/1,
д. 100-0000, Чингэлтэй дүүрэг Улаанбаатар хот, 15100
Утас: 011-21 52 47
Цахилгаан: 011-21 52 47
Улаанбаатар хотын захирагчтай

2022.09.15 № 68/МАН
Хугацаа: _____ Үнд. №: _____

**"МАСТЕР МАЙНИНГ СЕРВИС"
ХХК-д**

Танай ирүүлсэн хураалттай дагуу ажил эй зог хандыг үүсгэн, болон тээвэрлэх, цуглуулах, дахин боловсруулах, устгах, эхлэрлэх үйл ажиллагааг эхлэх аж ахуйн төрлөөс Байгаль орчин, аялал жуулчлалын яамны хог хаягдлын мэдээллийн сан дээрх мэдээлэл, бүртгэл №021009 дунд оруулан болохыг үүсгэн мэдэгдэж байга.

**ЗАХИРГА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ХҮРГИЙН ТҮР
ОРЛОН ТҮЙЦЭГ ЭЗЭН**

СОЖАМЬЯНДОЖ

110301187

Зураг 21. Хог хаягдлын мэдээллийн санд бүртгэгдсэн

✖ **ЦАХИМ ГҮЙЛГЭЭНИЙ БАРИМТ**

ШИЛЖҮҮЛЭГЧИЙН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ		ХҮЛЭЭН АВАГЧИЙН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ	
Банкны нэр:	ХасБанк	Банкны нэр:	Голомт Банк
Данс:	5002350840	Данс:	1715132986
Нэр:	-	Нэр:	Цэцүүх трейд ХХК
Дүн:	759,000.00	Дүн:	759,000.00
Валют:	MNT	Валют:	MNT

Гүйлгээний мэдээлэл
Гүйлгээний дугаар: 000002068701
Гүйлгээний утга: P03-шуудай устгал
Гүйлгээний шимтгэл: 200.00MNT
Гүйлгээний хүсэлт илгээсэн: _____ Гүйлгээ баталсан: _____

Гүйлгээ хийсэн огноо: 2022-10-03 11:12:11.0

Энэхүү цахим гүйлгээний баримтыг засварлах, мэдээлэл өөрчлөх болон аливаа хууль бус зорилгоор ашиглахыг хориглоно.

Зураг 22. “Цэцүүх трейд” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу сав баглаа боодлын хог хаягдлыг устгуулсан баримт

V.6. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 9. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

№	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зардал, 2022 он /төгрөг /
1	Дүүрэг орон нутагтай хамтран ажиллах гэрээ, байгуулж байгаль орчныг хамгаалах чиглэлийн ажилд хамтран ажиллах	Дүүрэг орон нутагтай хамтран ажилладаг. Байгаль орчныг хамгаалах чиглэлийн ажилд хамтран ажилласан.	-
2	Бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулах	Бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулж ажилласан.	-
3	Байгаль орчны аудит хийлгэх	-	-
4	Байгаль орчныг хамгаалах чиглэлээр, ажилчдын дунд сургалт семинарыг улиралд нэг удаа тогтмол зохион байгуулах	Байгаль орчныг хамгаалах чиглэлээр, ажилчдын дунд сургалт семинарыг зохион байгуулсан.	-
5	MNS ISO 14001:2016 “Байгаль орчны менежментийн тогтолцоо – шаардлага, хэрэглэх арга зүйн заавар”, Зарчим, тогтолцоо, дэмжих аргачлалын заавар” стандартад сайжруулалт хийх	-	-
6	Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж байх	Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж ажилласан. Орон нутагтай хамтарч ажилласан талаар: 1. Урлаг наадмыг ивээн тэтгэсэн, 2. 200м ² подьвол засч тохижуулсан, 3. Баяруудаар бэлэг тараасан, 4. Өвөл, өвс тэжээл гэх мэт тараасан.	23,000,000

7	Болзошгүй осол, гал унтраах хэрэгслээр байгууллагыг бүрэн хангах ар хэмжээ авах, гал унтраах талаар тодорхой түвшинд бэлтгэлийг хангуулах арга хэмжээ зохион байгуулах.	Гал унтраах багаж хэрэгслийг зохих газруудад байршуулсан. Галын аюулгүй байдлыг анхааруулсан санамж тэмдгийг зохих газруудад байршуулсан.	300,000
9	Компанийн үйл ажиллагаа, БО хамгаалах талаар мэдээллээр хангах /дүүрэг, орон нутаг/	БО хамгаалах талаар мэдээллээр хангаж ажилласан.	-
Нийт дүн			23,300,000



Зураг 23. Подволь засч тохижуулсан байдал



Зураг 24. Подволь засч тохижуулсан байдал



Зураг 25. Урлагийн наадмыг ивээн тэтгэсэн байдал



Зураг 26. Урлагийн наадмыг ивээн тэтгэсэн байдал

V.7. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөний биелэлт

"МАСТЕР МАЙНИНГ СЕРВИС" ХХК нь жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллага, нутгийн иргэдэд тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд хүргүүлнэ.

Хүснэгт 10. Олон нийтэд тайлагнах, танилцуулах төлөвлөгөөний биелэлт

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд		Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Хэрэгжүүлсэн арга хэмжээ
УБ, Багахангай дүүрэг	Орон нутгийн байгаль орчны газар	Тайлан хэлбэрээр	БОМТ-ний 2022 оны хэрэгжилтийн тайлан	11-р сарын 01-ны өдрийн дотор	БОМТ болон, БОМТ-ний биелэлтийн тайланг хянуулахаар ажиллаж байна.
	БОАЖЯ-ны ХБОБНУГ	Тайлан хэлбэрээр			

V.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

Хүснэгт 11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөөний биелэлт

№	Хяналт шинжилгээ явуулах үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зардал, 2022 он /төгрөг/
Агаарын орчин				
1	Агаар орчны шинжилгээ	Үйлдвэр, агуулахын орчмоос	-	-
Усан орчин				
2	Ус хүнд металл, химийн үзүүлэлтээр	Үйлдвэр, агуулахын орчмоос	-	-
Хөрсөн бүрхэвч				
3	Хөрсний хүнд металлын үзүүлэлтээр	Үйлдвэр, агуулахын орчмоос	-	-
Нийт дүн				

2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ЗАРЦУУЛСАН НИЙТ ЗАРДАЛ

“МАСТЕР МАЙНИНГ СЕРВИС” ХХК-ийн 2022 оны БОМТ-ний биелэлтийн тайланг БОАЖ-ын Сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсрууллаа.

2022 онд БОМТ-нд нийт **41,209,000.00** төгрөг зарцуулж ажиллалаа.

Хүснэгт 12. 2022 оны БОМТ-нд зарцуулсан нийт зардал

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зардал, 2022 он /төгрөг/
1	Байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	3,300,000
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт	8,000,000
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	-
6	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	1,109,000
7	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	5,500,000
8	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	23,300,000
9	Олон нийтэд тайлагнах төлөвлөгөөний биелэлт	-
11	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	-
Нийт дүн		41,209,000

ДҮГНЭЛТ

Улаанбаатар хотын Багахангай дүүргийн нутагт орших “МАСТЕР МАЙНИНГ СЕРВИС” ХХК-ийн “Тэсрэх бодисын үйлдвэр, агуулах”-ын 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу биелэлтийн тайланг боловсруулж дараах дүгнэлтэд хүрлээ.

“МАСТЕР МАЙНИНГ СЕРВИС” ХХК-ийн 2022 оны БОМТ-ний биелэлтийн тайланг БОАЖ-ын Сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсрууллаа.

Уг төслийн явцад байгаль экологийн унаган төрхийг хамгаалахын тулд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний дүн, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө зэргийг мөрдлөг болгон ажиллаж, 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж ажилласан.

“МАСТЕР МАЙНИНГ СЕРВИС” ХХК нь нь 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу сөрөг нөлөөллийг бууруулах ажлууд болох үйлдвэр агуулахыг стандартад нийцүүлж, барьсан, үйлдвэрийн хашааг тохижуулсан, тэсрэх бодисын сав баглаа боодлыг цуглуулж, хог тээвэрлэлтийн гэрээ байгуулж тээвэрлүүлсэн, үйлдвэрийн орчмыг гал түймрээс сэргийлсэн багаж хэрэгслээр хангасан, анхааруулах санамж тэмдгийг байршуулсан, үйлдвэр агуулахын хашаан дотоод тээвэрлэлтийн нэг замын маршрутын дагуу тээвэрлэлт хийсэн, ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглээр хангаж, эрүүл мэндийн үзлэгт хамруулсан, орон нутагтай хамтарч ажиллах зэрэг тодорхой ажлуудыг хийж хандив тусламж өгч ажилласан.

“Тэсрэх бодисын үйлдвэр, агуулах”-ын 2022 оны БОМТ-нд тусгагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд нийт 41,209,000 төгрөг зарцууллаа.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995 он
2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 2012 он
3. Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын 2014 оны А-117 тоот тушаал Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачилсан заавар
4. “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” БОАЖСайдын А/618 тоот тушаал, 2019 он.
5. Улаабаатар хотын Багахангай дүүргийн нутагт орших “Тэсрэх бодисын үйлдвэр, агуулах”-ын төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, 2022 он
6. Улаабаатар хотын Багахангай дүүргийн нутагт орших “Тэсрэх бодисын үйлдвэр, агуулах”-ын төслийн БОМТ, 2022 он
7. <http://www.legalinfo.mn/>
8. www.met.gov.mn
9. ArcGIS 10.5